



МОНГОЛ УЛС

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН

ТУШААЛ

20²¹ оны 05 дугаар
сарын 11-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 53.1, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1, 2.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын стратеги төлөвлөгөөг 1 дүгээр, Үндэсний хөгжлийн газрын стратеги төлөвлөгөөг 2 дугаар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын стратеги төлөвлөгөөг 3 дугаар, Удирдлагын академийн стратеги төлөвлөгөөг 4 дүгээр, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын стратеги төлөвлөгөөг 5 дугаар, МОНЦАМЭ агентлагийн стратеги төлөвлөгөөг 6 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Батлагдсан стратеги төлөвлөгөөг мөрдөж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Үндэсний хөгжлийн газрын дарга Х.Батжаргал, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэг, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга Ж.Тамир, МОНЦАМЭ агентлагийн дарга Б.Ганчимэг нарт даалгасугай.


Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ


000021200134

Засгийн газрын Хэрэг эрхлэх
газрын даргын 2021 оны 34 дугаар
тушаалын 2. дүгээр хавсралт



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2021-2024 ОН)

ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА



Б.Болор-Эрдэнэ

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Улаанбаатар хот

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

Нэг.Нийтлэг үндэслэл	4
Хоёр.Мандатын шинжилгээ	4
Гурав.Орчны шинжилгээ	8
Дөрөв.Алсын хараа	12
Тав.Эрхэм зорилго	12
Зургаа.Стратегийн зорилт	12
Долоо.Стратегийн зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам.....	14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн нэгдсэн улс
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ДЦХБ	Дэлхийн цахилгаан холбооны байгууллага
ДШХБ	Дэлхийн шуудан холбооны байгууллага
МТХХ	Мэдээллийн технологи, харилцаа холбоо
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбоо, технологи
НОК	Нийслэлийн онцгой комисс
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУЦХБ	Олон улсын цахилгаан холбооны байгууллага
РТҮС УТҮГ	"Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газар
ТӨК	Төрийн өмчит компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УОК	Улсын онцгой комисс
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Харилцаа холбоо мэдээллийн технологийн газрын стратеги төлөвлөгөөг Төрийн албаны тухай хуулийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-ыг баримтлан боловсруулсан.

Тус стратеги төлөвлөгөөг Харилцаа холбоо мэдээллийн технологийн газрын ерөнхий чиг үүрэг болох сансрын технологи, харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, инновац, мэдээллийн аюулгүй байдал, цахим засаглалын талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын хөгжлийн стратегийг тодорхойлох, бодлогын удирдамжаар хангах, төрийн захиргааны удирдлагаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах хэрэгцээ, шаардлагын хүрээнд боловсруулав.

ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Харилцаа холбоо мэдээллийн технологийн газарт хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд Мандатын шинжилгээг хийж, дор дурдсан хүснэгтээр тодорхойлов.

Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		22	
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	1	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
		2	Харилцаа холбооны тухай хууль
		3	Өргөн нэвтрүүлгийн тухай хууль
		4	Радио долгионы тухай хууль
		5	Цахим гарын үсгийн тухай хууль
		6	Шуудангийн тухай хууль
		7	Хувь хүний нууцын тухай хууль
		8	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	9	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
		10	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
		11	Гамшгаас хамгаалах тухай хууль
		12	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
		13	Нийтийн сонсголын тухай хууль
		14	Олон улсын гэрээний тухай хууль
		15	Төрийн албаны тухай хууль
		16	Төрийн болон албаны нууцын тухай хууль
		17	Төсвийн тухай хууль
		18	Улсын бүртгэлийн ерөнхий хууль
		19	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай.
		20	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

	21	Холбогдох бусад хууль тогтоомж
Ерөнхий чиг үүрэг-1: Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбоо, шуудан, мэдээллийн аюулгүй байдлын салбарын хүрээнд хууль тогтоомжийн төсөл, бодлогын баримтлах чиглэл боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээж, Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэргэжлийн бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.		
Үндсэн чиг үүрэг (ҮЧҮ)	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын стратеги бодлого, төлөвлөлтийг боловсруулах	Харилцаа холбооны асуудлаар бодлого боловсруулах	Яамд, ХХЗХ, Хувийн хэвшил
	Харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын биелэлтийг зохион байгуулах	Яамд, ХХЗХ, Хувийн хэвшил
	Өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбогдсон журам, заавар, аргачлал батлах	Яамд, ХХЗХ, Хувийн хэвшил
	Хүний хөгжлийг дэмжиж, эдийн засаг, нийгмийн бүх салбаруудад мэдээллийн технологийн дэвшил, инновацыг нэвтрүүлэх	Яамд, ХХЗХ, Хувийн хэвшил
	Сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах, батлах (өргөн зурвасын дамжуулах сүлжээ, түгээх сүлжээ)	ХХЗХ, Хувийн хэвшил
	Үндсэн сүлжээ (хот хоорондын болон улс хоорондын сүлжээ)-г өргөтгөн хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах	ТӨК, Хувийн хэвшил
	Дотоодын интернэтийн дундын холболтыг зохицуулах	ХХЗХ, Хувийн хэвшил
	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх үйлчилгээний төлбөр, хураамжийг хэмжээг тодорхойлох	ХХЗХ, Хувийн хэвшил
	Харилцаа холбооны үйлчилгээний найдвартай, шуурхай, чанартай байдал хяналт тавих	ХХЗХ, ТӨК, Хувийн хэвшил
	Төрөөс иргэдэд хүргэх радио, телевизийн нэвтрүүлгийг дамжуулах үйлчилгээний журам	ХХЗХ, РТҮС УТҮГ, Хувийн хэвшил
	Шуудангийн нэгдсэн кодын төлөвлөлт	ХХЗХ, Хувийн хэвшил
	Шуудангийн үндсэн сүлжээний бодлого, төлөвлөлт	ХХЗХ, Хувийн хэвшил
	Шуудангийн маркийн үйлдвэрлэлт, борлуулалт, дахин үнэлэлт	ХХЗХ, Хувийн хэвшил
	Шуудангийн маркийн улсын фондын баяжуулалт, хадгалалт, хамгаалалт, төлөвлөлт	ХХЗХ, Хувийн хэвшил
	Шуудангийн логистик үйлчилгээний бодлого, төлөвлөлт	ХХЗХ, Хувийн хэвшил
	Гамшгаас хамгаалах харилцаа холбооны албаны чиг үүрэг хэрэгжүүлэх	ОБЕГ, УОК, НОК, ХХЗХ, Хувийн хэвшил, ҮДТ УТҮГ
	Инновац, судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бий болгож, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, олон улсын зах зээлд өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх	Яамд, ХХЗХ, Хувийн хэвшил
	Засгийн газраас салбар хооронд харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх бодлого, төлөвлөлт хийх	Яамд, ХХЗХ, Хувийн хэвшил
	Мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, кодчиллыг боловсронгуй болгох	ХХЗХ, Хувийн хэвшил
	ХХМТ-ийн энтрепренёршип ба хүний нөөцийг хөгжүүлэх хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах	Яамд, ХХЗХ, Хувийн хэвшил
	Инновац, судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бий болгож, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, олон улсын зах зээлд	Яамд, ХХЗХ, Хувийн хэвшил

	өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх	
2. Цахим хөгжлийн хэрэгжилтийг хангах	Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхжүүлэх, төрийн үйл ажиллагааны инновацыг дэмжиж, цахим засгийн хөгжлийг боловсронгуй болгох	Яамд, ХХЗХ, Хувийн хэвшил
	Цахим засгийн хатуу болон зөөлөн дэд бүтэц тасралтгүй хөгжүүлэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт нэгдсэн бодлого, төлөвлөлттэйгөөр шилжүүлэх	Яамд, ХХЗХ, ТӨК, УТҮГ, Хувийн хэвшил
	Харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	Яамд, ХХЗХ, ТӨК, УТҮГ, Хувийн хэвшил
	Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас Засгийн газраар шийдвэрлүүлэх харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт хийх	Яамд, ХХЗХ, ТӨК, УТҮГ, Хувийн хэвшил
	Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэвийн найдвартай ажиллагааг хангах	Яамд, ХХЗХ, ТӨК, УТҮГ, Хувийн хэвшил
	Бүх нийтийн тоон бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх	Яамд, ХХЗХ, Хувийн хэвшил
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл чөлөөтэй авах боломжийг бий болгох	Яамд, ХХЗХ, ТӨК, УТҮГ, Хувийн хэвшил, ТББ
	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх хангах	Яамд, ЗГХЭГ, ХХЗХ, Хувийн хэвшил
	Цахим орчинд монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх	Яамд, ЗГХЭГ, ХХЗХ, Хувийн хэвшил
3. Сансрын холбооны бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх	Захиргааны байгууллагын цахим мэдээллийн санг байршуулах, шинэчлэх, хадгалах, түүхчилсэн бүртгэл үүсгэх, ашиглах	Яамд, Төрийн үйлчилгээний байгууллага, ЗГХЭГ, ХХЗХ, Хувийн хэвшил
	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх иргэн, байгууллагуудыг шаардлага хангуулах, эрх олгох, хийх аргачлалаар хангах, бүртгэл хөтлөх, аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалтыг боловсруулах, холбогдох дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах	ХХЗХ, ДЦХБ, СҮЗ
4. Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг хангах	Радио давтамжийн харилцан нөлөөлөл	ҮАБЗ, ХХЗХ, ДЦХБ, СҮЗ
	Радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалт	Яамд, ХХЗХ, ТӨК, УТҮГ, Хувийн хэвшил
5. Шуудан, радио телевизийн бодлогын хэрэгжилтийг хангах	Сансрын холбоо, хиймэл дагуулын бодлого, төлөвлөлт	Яамд, Төрийн үйлчилгээний байгууллага, ЗГХЭГ, ХХЗХ, Хувийн хэвшил
	Үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, байгууллагын мэдээллийн бүрэн бүтэн байдал, үнэн зөв, хамгаалалттай, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах замаар мэдээллийн аюулгүй байдлыг хангах	ХХЗХ, Хувийн хэвшил
	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт	ХХЗХ, Хувийн хэвшил
	Цахим орчны хэрэглээ, аюулгүй байдал	Яамд, ХХЗХ, ТӨК,

		ТББ
	Телевизийн өргөн нэвтрүүлгийн бодлого, төлөвлөлт	ХХЗХ, ТӨК, Хувийн хэвшил
6. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлыг салбарын болон байгууллагын түвшинд хэрэгжүүлэх	Радиоогийн өргөн нэвтрүүлгийн бодлого, төлөвлөлт	Яамд, ЗГХЭГ, ХХЗХ, Хувийн хэвшил
	Тоон контентын бодлого, төлөвлөлт	Яамд, ЗГХЭГ, ХХЗХ, Хувийн хэвшил
	Шуудангийн салбарт төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах	ХХЗХ, Хувийн хэвшил
	Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагын харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хэрэгжилтийн явцад үнэлгээ хийх	ХХЗХ
	Харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хэрэгжилтэд үнэлгээ хийх	ХХЗХ
	Харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хэрэгжилтэд үнэлгээ хийх	ХХЗХ
	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах	ХХЗХ
	Сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих	ХХЗХ, ШӨХТГ
7. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах	Үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих	ЗГХЭГ
	Харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник технологийн горимын хэрэгжилтэд хяналт тавих	ЗГХЭГ, ХХЗХ
	Өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбогдсон журам, заавар, аргачлалын хэрэгжилтийг зохион байгуулах	ГХЯ
	Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөхөд эрх бүхий байгууллагатай зөвшилцөх, санал өгөх	ХХЗХ
8. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг ханган ажиллах	Харилцаа холбооны талаар төрөөс баримталж буй бодлогыг хэрэгжүүлэхэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, холбогдох байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх	ЗГХЭГ
	Эрхэлсэн асуудлаар олон улсад Монгол Улсыг төлөөлөх	Хяналтын зөвлөл
	Харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын биелэлтийг зохион байгуулах	БНҮҮС
	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн бодлого, төлөвлөлт хийх	БНҮҮС

ГУРАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын өнөөгийн байдлын талаар:

Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд салбаруудын мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, төрөөс баримтлах бодлогыг улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж өнөөг хүртэлх жилийн хугацаанд хөдөө орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх техник технологийн суурь дэд бүтэц бүрдэж шилэн кабелийн сүлжээний нийт урт 43,940 км, радио релейний сүлжээний тархалт 8,400 км-т хүрч, манай улсын бүх аймаг сумын төв, томоохон суурин газруудад суурин болон хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбогдсон.

Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 2002 онд 235.0 мянга байсан бол өнгөрсөн оны хагас жилийн байдлаар 4 сая 418.0 мянгад хүрч, 100 хүнд ногдох үүрэн телефон хэрэглэгчийн тоо 129 болсон нь хөгжиж буй орнуудын болон дэлхийн дунджаас харьцангуй өндөр байна. Хөдөлгөөнт холбооны 4 дэх үеийн технологийг 2016 онд нэвтрүүлэн одоогийн байдлаар 1 сая 900 мянга гаруй хэрэглэгчтэй болоод байна.

Монгол Улсад интернэтийн үйлчилгээ нэвтэрсэн 25 жилийн хугацаанд 60 гаруй компани интернэтийн үйлчилгээ эрхэлж, гадаад гарцын урсгалын хэмжээ 155,2 Гбит/сек, интернэтийн хэрэглэгчдийн тоо давхардсан тоогоор 5,450.61 мянга хүрснээс 94,41 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын үйлчилгээг хэрэглэж байна.

Мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг төрийн болон хувийн хэвшлийн 29 их дээд сургуульд 3,000 гаруй оюутан суралцаж байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр 5.0 мянга 200 гаруй байгууллага үйл ажиллагаа эрхэлж, 25,000 орчим ажилтан ажилладаг.

Өнөөдөр улс орон даяар урт, дунд, богино долгионы их чадлын 6 станцаар үндэсний олон нийтийн радиогийн өргөн нэвтрүүлгийн 1, 2 дугаар программыг дамжуулж, нийт нутаг дэвсгэрийн 90 гаруй хувь нь дунд сонсголын, хүн амын 75 гаруй хувь нь найдвартай сонсголын бүсэд хамрагдаж байна. Мөн телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг 737.4 мянган хэрэглэгч кабелийн болон утасгүй кабелийн, эфирийн, хиймэл дагуулын, интернэт протоколд суурилсан, хөдөлгөөнт телевизийн сүлжээгээр хүлээн авч байна.

Монгол Улсын шуудангийн салбарын хууль эрх зүй, зохицуулалтын таатай орчин бүрдэж зах зээлийн өрсөлдөөн нэвтэрсэн ба шуудангийн үйлчилгээний хүртээмж чанар жилээс жилд сайжирсаар байгаа билээ.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого нь 2008 онд 365.2 тэрбум төгрөг байсан бол жил бүр тасралтгүй өссөөр 2015 оны байдлаар 1 их наяд 3.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд ДНБ-ний 3.2 хувийг бүрдүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 101 дүгээр тогтоолоор баталсан "Цахим засаг", 2019 оны 73 дугаар тогтоолоор баталсан "Цахим засаглал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн мэдээллийн систем, мэдээллийн санг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэдийн өргөдөл гомдлыг цахим хэлбэрээр авч шийдвэрлэх, төрийн үйлчилгээг ТҮЦ машинаар дамжуулан иргэдэд хүргэх, гамшгийн аюулыг урьдчилан мэдээлэх, шилэн данс, нэмэгдсэн өртгийн албан татварын систем хөгжүүлэх

зэрэг ажлыг хийж гүйцэтгэж төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем төрийн 27 байгууллага, хувийн хэвшлийн 163 байгууллага холбогдон төрийн байгууллагаас үзүүлдэг 181 нэр, төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж эхлээд байна. Түүнчлэн ТҮЦ машины үйлчилгээг давхардсан тоогоор 2020 онд 1.8 сая иргэн үйлчлүүлж, нэг үйлчилгээ авахад 1 цаг 40 минут хэмнэсэн байна.

Гэсэн хэдий ч мэдээллийн технологи, харилцаа холбооны дэвшлийг бүх нийтийн хүртээл болгох, мэдлэг шингэсэн, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дижитал эдийн засгийг бэхжүүлэхэд дараах хүндрэл бэрхшээл тулгарсаар байна. Үүнд:

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д мэдээллийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэмээн зарлаж, тодорхой зорилтуудыг дэвшүүлж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлын үндэсний стратеги /Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр/-аа 2010-2015 онд хэрэгжүүлсэн. Гэвч бодит байдалд 2010-2015 онд хэрэгжүүлсэн Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн биелэлт 50 хувиас доогуур үзүүлэлттэй гарсан. Дээрх хүчин зүйлээс харахад Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хангах асуудал нь хүн, төр, хувийн хэвшлийн кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, аюул заналыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, цахим мэдээллийн дэд бүтцийг хамгаалах бодлого, зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

- Монгол Улсын Засгийн газраас цахим засаглалыг хөгжүүлэхээр бодлого батлан төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн боловч төрийн цахим харилцааны удирдлага, манлайлал, төрийн захиргааны төв байгууллагын үүрэг, оролцоо хангалтгүй байгаатай холбогдон УИХ-аас гаргасан тогтоол, шийдвэр, Засгийн газрын бодлого, хөтөлбөрийн биелэлт хангалтгүй байх, төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиглэлийн ажлын уялдаа, төсөл, хөтөлбөрийн зохицуулалт алдагдах, төрийн байгууллагын цахим шилжилт удаашрах, шилжилтийн түвшин харилцан адилгүй байх, хоцрогдсон технологи нэвтрүүлэх, үр ашиг багатай, давхардсан хөрөнгө оруулалт хийх, гадаад дотоодын санхүүжилтээр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслийн нэгдсэн удирдлага, зохицуулалт хангалтгүй, төрийн цахим харилцааны олон улсын хөгжлийн үзүүлэлтэд ахиц гарахгүй, зарим жилүүдэд ухралт гарч байгааг холбогдох судалгаагаар тогтоосон.

- Монгол Улсын мэдээллийн технологийн салбарын хөгжлийн өнөөгийн түвшин, дэлхий нийтийн чиг хандлагын дагуу иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын хооронд харилцан мэдээлэл солилцох, төрийн мэдээлэлд хандах, ашиглах, төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, төрийн мэдээллийн үнэ цэнийг өсгөх, төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд технологи, инновацын тусламжтай цахим шилжилт хийх шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

- Уул уурхай, хөдөө аж ахуй давамгайлсан эдийн засгийн өнөөгийн бүтцийг өндөр технологи, мэдлэг инновацад суурилсан дэвшилтэд дижитал эдийн засгийн бүтцэд шилжүүлэх бүтцийн дорвитой өөрчлөлт хийх замаар салбар хоорондын хөгжлийг дэмжих технологи-инновацын хөтөлбөр хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт-бизнесийн таатай орчин бүрдүүлж өндөр технологийн чиглэлийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, дижитал өрсөлдөх чадварыг урагшлуулан нийгэм-эдийн засгийн бүтээмжийг дээшлүүлэх шаардлага гарч байна.

Гадаад орчин	
Боломж	Эрсдэл
Хөрш орнуудын хувьд: 1. Хөрш орнуудын хувьд шинжлэх ухааны суурь хөгжил сайн; 2. Хөрш орнуудын хувьд дижитал эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны бодлого гаргаж анхааран ажилладаг; 3. Хөрш орнуудын хувьд олон сая хүн амтай, том зах зээлтэй; 4. Программ хангамжийн бүтээгдэхүүн экспортлох боломжтой; 5. Технологид суурилсан гарааны бизнесүүд хөрш орнуудын зах зээлд гарах боломжтой; 6. Сансрын судалгаан дээр хамтарч ажиллаж байсан арвин туршлагатай, цаашид хамтарч ажиллах боломж өндөр; 7. Сансрын судалгаан дээр хамтарч ажиллаж байсан арвин туршлагатай, цаашид хамтарч ажиллах өндөр боломжтой. Гурав дахь хөрш орнуудын хувьд: 8. Дижитал эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны бодлого гарган хамтран ажиллах боломжтой; 9. Салбарын нөөцийн чадавхжуулахад хамтрах ажиллах боломжтой; 10. 3 дахь хөрш орнуудад тухайлбал БНСУ-д Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэжлээр чанартай боловсролыг харьцангуй хямд үнээр авах боломжтой; 11. Технологид суурилсан гарааны бизнесүүд АНУ, БНСУ-ын зах зээлд гарах боломжтой; 12. Инновацийн эко систем бүрдүүлэх чиглэлд хамтын ажиллагааг өрнүүлэх боломжтой. Олон улсын байгууллагуудын хувьд (ОУЦХБ, ДШХБ): 13. Монгол Улсын эрх ашигт нийцсэн зохицуулалтыг олон улсад хэрэгжүүлэх; 14. Аль ч улстай шууданг чөлөөтэй солилцох; 15. Харилцаа холбооны хязгаарлагдмал нөөцийг тэгш ашиглах; 16. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх; 17. Хүний нөөцийг чадавхжуулах, туршлага судлах; 18. Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авах;	Хөрш орнуудын хувьд: 1. Манай улс руу кибер халдлага ихтэй; 2. Хөрш орнуудтай хийгдэх хамтын ажиллагааг ижил түвшинд явуулах, хадгалах шаардлага тулгардаг; 3. Хиймэл дагуулын радио давтамжийн хортой интерференцийн нөлөөлөл үзүүлэх боломжтой; 4. IoT, Дрон зэрэг радио долгионоор ажилладаг тоног төхөөрөмж ашиглан хил орчимд хяналт хийх боломжтой; 5. Дрон ашиглан хориотой бараа бүтээгдэхүүн хил гаалиар нэвтрэх; 6. Хиймэл дагуулын радио давтамжийн хортой интерференцийн нөлөөлөл үзүүлэх боломжтой; 7. IoT, Дрон зэрэг радио долгионоор ажилладаг тоног төхөөрөмж ашиглан хил орчимд хяналт хийх боломжтой; 8. Дрон ашиглан хориотой бараа бүтээгдэхүүн хил гаалиар нэвтрэх. Гурав дахь хөрш орнуудын хувьд: 9. Контентоор дамжуулж соёлын нөлөөлөл үзүүлдэг; 10. Манай улс руу кибер халдлага ихтэй; 11. Зарим 3 дахь хөрш орнууд манай хөрш орнуудтай харилцаа сул.

• “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигт Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьсан. Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын үед улс орнууд ижил гараан дээр байгаа энэ үед Монгол Улсын хувьд мэдээллийн технологи, блокчэйн суурилсан платформууд, программ хангамж, үндэсний тоон контент болон газрын ховор элемент ашиглан электроникийн үйлдвэрлэл хөгжүүлж, экспортод гарган эдийн засгийн шинэ секторыг бий болгох шаардлагатай байна.

Хүснэгт 2. Орчны шинжилгээний нэгдсэн хүснэгт

Дотоод орчин	
Давуу тал	Сул тал
1. Монгол Улсын 21 аймгийн төв, 320 гаруй сум шилэн кабелийн сүлжээнд холбогдон интернэт, үүрэн холбооны 3G/4G үйлчилгээ авч байгаагийн зэрэгцээ аймгийн түвшний харилцаа холбооны сүлжээний багтаамж 100 Мб/с, олон улсын интернэтийн урсгалын багтаамж 215 Гб/с хүрсэн. Интернэт хэрэглэгчдийн тоо 300 мянга, гар утас хэрэглэгчдийн тоо 4,4 сая, түүний дотор ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо 3,2 саяд хүрсэн. 2. Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем (2017), Танилт нэвтрэлтийн “ДАН” систем (2018), Төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia.mn систем (2020), Үндэсний цахим шуудан (2020) зэрэг суурь системүүдийг хөгжүүлэн ашиглалтад оруулсан. Дээрх системүүдийн тусламжтай 27 байгууллагын 181 үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж байна. 3. “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем”-ийг хөгжүүлэн 2020 онд ашиглалтад оруулснаар төрийн захиргааны болон төрийн өмчийн 43 байгууллага, Нийслэлийн нутгийн захиргааны 1148 байгууллага, 21 аймгийн ЗДТГ, нутгийн удирдлагын 542 байгууллага буюу нийтдээ 1733 байгууллагын 24973 албан хаагч ашиглаж байна.	1. УИХ-аас 2020 онд баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д салбарын хөгжлийн чиглэлээр туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хүрэлцээ, орон тоо бага. Энэ нөхцөл, байдалтай уялдан агентлагийн албан хаагчдын ажлын ачаалал их, зарим талаар мэдлэг, ур чадвар дутах эрсдэл байна. Төрийн захиргааны байгууллагын цалин, урамшууллын өнөөгийн нөхцөлтэй холбоотойгоор албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах байдал хангалтгүй байна. 2. Төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх хамт хэрэгжүүлэх иргэд болон төрийн албан хаагчдын технологи ашиглалтын ур чадварыг сайжруулах, дадлагажуулах чиглэлээр ажил хийгдэхгүй байна. 3. Цахим орчны хууль эрх зүйн орчин хараахан бүрэлдээгүй байна. 4. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний тогтолцоо бүрдээгүй, чадавх сул байна. 5. Салбар хоорондын цахимжилтын төсөл, хөтөлбөрийн уялдаа, зохицуулалт сул байгаа нь үр ашиггүй, давхардсан хөрөнгө оруулалт хийх, хоцрогдсон эсвэл харилцан нийцэлгүй технологи нутагшуулах эрсдэлд хүргэж байна. 6. Сумын түвшний интернэтийн багтаамж сул, харилцан адилгүй түвшинд байгаа нь хөдөө орон нутагт тоон ялгаа бий болох шалтгаан болж байна. 7. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, шаардлагатай уялдан салбарын хөгжлийг хариуцсан Засгийн газрын тохируулагч агентлагийн статусыг төрийн захиргааны төв байгууллагын түвшинд хүргэх шаардлага байгаа.

ДӨРӨВ.АЛСЫН ХАРАА

Мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжил, дэвшил нь Монгол Улсын хөгжлийн хурдасгуур байна.

ТАВ.ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэдээллийн технологи, харилцаа холбооны дэвшлийг бүх нийтийн хүртээл болгох, мэдлэг шингэсэн, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар дижитал эдийн засгийг бэхжүүлэхэд оршино.

ЗУРГАА.СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

1. Салбарын эрх зүйн орчныг хөгжүүлэх санал боловсруулах;
2. Мэдээллийн технологи, харилцаа холбоо, шуудан, сансар, мэдээллийн аюулгүй байдлын дунд, богино хугацааны бодлогыг төлөвлөх;
3. Салбарын судалгаа, шинжилгээг хийж, салбарын хөгжлийн бодлого, төсөл хөтөлбөрийн хувилбар боловсруулах, стандартчиллыг хөгжүүлэх;
4. Мэдээллийн технологи, харилцаа холбоо, радио, телевизийн өргөн нэвтрүүлэг, шуудангийн салбарын хөгжлийн бодлогын удирдамжаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг зохицуулах;
5. Мэдээллийн технологи, харилцаа холбоо, шуудан, сансрын салбарын материаллаг нөөц, техник хангамж, суурь дэд бүтэц болон гамшгийн үеийн холбооны сүлжээний зохион байгуулалтыг төлөвлөх;
6. Цахим засаглал, төрийн үйлчилгээнд инновац нэвтрүүлэх ажлын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;
7. Нийгэм, эдийн засгийн салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэглээ бий болгох хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;
8. Төрийн байгууллагуудын өгөгдлийн сан, мэдээллийн системийг нэгдсэн бодлогоор уялдуулах, хөгжүүлэх, нээлттэй өгөгдлийг нэвтрүүлэх, цахим гарын үсгийн нэгдсэн тогтолцоо, харилцан мэдээлэл солилцох техникийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;
9. Харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх;
10. Үндэсний радио давтамжийн нөөцийг үр ашигтай, зүй зохистой ашиглах, шударга, тэгш хуваарилах ажлыг төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
11. Сансрын болон дэвшилтэт технологийг нутагшуулах, газар, сансар хосолсон өргөн зурвасын сүлжээг бий болгох, хэрэглээг нэвтрүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;
12. Тандан судалгааны мэдээг үндэсний хэмжээнд ашиглах, хэрэглээг нэвтрүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

13. Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулах;

14. Шуудангийн салбарт орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, технологийг нутагшуулах, хөтөлбөр, төслийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

15. Нийгмийн мэдээллийн сүлжээ болон цахим хуудас, интернэтээр дамжиж байгаа бүх төрлийн контентыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

16. Иргэдийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн зөв зохистой хэрэглээний соёлыг төлөвшүүлэх, цахим орчин, нийгмийн мэдээллийн сүлжээг ашиглах мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах;

17. Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

18. Бүх нийтийн мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг ойлголт, зохистой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, төр хувийн хэвшлийн байгууллагатай хамтарч ажиллах;

19. Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр үндэсний үйлдвэрлэл, стандартчиллыг хөгжүүлэх;

20. Гадаад хамтын ажиллагааны удирдлага зохицуулалтад дэмжлэг үзүүлэх;

21. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх;

22. Эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах;

23. Албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх, ажиллах, нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх;

24. Мэдээллийн ил тод байдал, цахим үйл ажиллагааг хангах, байгууллагын санхүүг эрхлэх;

25. Хууль тогтоомж, гэрээ хэлэлцээр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнг үнэлэх;

26. Газрын болон салбарын байгууллагуудын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

27. Салбарын статистик мэдээ гаргах, мэдээллийн сан байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

ДОЛОО.СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Хүснэгт 3. Стратегийн зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам

Зорилт	Хэрэгжүүлэх арга зам /стратеги /	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүү-жилт /сая төгрөг/	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүрэг. Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбоо, шуудан, мэдээллийн аюулгүй байдлын салбарын хүрээнд хууль тогтоомжийн төсөл, бодлогын баримтлах чиглэл боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээж, Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэргэжлийн бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.						
Үндсэн чиг үүрэг: Мэдээллийн технологи, харилцаа холбоо, шуудан, радио давтамж, сансрын технологийн салбарын хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх						
1. Салбарын эрх зүйн орчныг хөгжүүлэх санал боловсруулах	1.1. Цахим хөгжлийг дэмжих, төр, иргэн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах хуулийн төсөл боловсруулах	Хуулийн төсөл-3	3 хуулийн тандан судалгааг хийсэн.	Хуулийн төслийг боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	-	
	1.2. Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах	Боловсруулсан саналын тоо	-	Жил тутам 5-аас доошгүй санал боловсруулна.	-	
	1.3. Салбар хоорондын уялдааг хангах эрх зүйн орчныг сайжруулах	Өөрчлөлт оруулсан баримт бичгийн тоо	Холбогдох эрх зүйн орчин бүрдсэн.	Жилд 3-аас доошгүй санал, зөвлөмж	-	
